



**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЕРӨӨ СУМЫН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

117, Гэрэлт гудамж, Буурагчин,  
2 дугаар баг, Ерөө сум, 43010

Утас/факс: (976) 70366473, Цахим шуудан: [eruu@selenge.gov.mn](mailto:eruu@selenge.gov.mn)

Цахим хуудас: [eruu.se.gov.mn](http://eruu.se.gov.mn)

*2024. 10. 25*

№


*139*

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН  
СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
САЛБАР ЗӨВЛӨЛД**

Ерөө сумын Засаг даргын Тамгын газарт гүйцэтгэх албан тушаалын сул орон тоо гарсан тул төрийн жинхэнэ албан хаагчийг шилжүүлэх, сэлгэн ажиллуулах тухай зарыг Төрийн албаны цахим хаягаар нийтэд зарлаж өгнө үү.

ДАРГА



С.ЦЭВЭЛМАА

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН НУЛГИЙН ЗАХИРГАДНЫ БАЙГУУЛЛАГУУДЫН ГҮЙЦЭТГЭХ АЛБАН ТУШААЛ**  
**/ДЭС/-ЫН СУЛ ОРОН ТООНД ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙГ**  
**ШИЛЖҮҮЛЭХ, СЭЛГЭН АЖИЛЛУУЛАХ ТУХАЙ ЗАР**

2024.10.25

Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 25 дугаар тогтоолоор батлагдсан Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журмын 4 дүгээр зүйлийн 4.2-т заасны дагуу төрийн өөр байгууллага, нэгж хооронд шилжин ажиллахыг хүссэн төрийн холбогдох бусад байгууллагад ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчдыг дараах албан тушаалд холбогдох материалаа цахим шуудангаар ирүүлэхийг урьж байна.

**Тавигдах болзол, шаардлага:**

- төрийн жинхэнэ албан тушаалд зохих ёсоор томилогдсон байх;
- зарлагдсан албан тушаалтай адил төрөл болон адил ангилалд ажилладаг байх;
- зарлагдсан албан тушаалын тодорхойлолтод заасан тусгай шаардлагыг хангасан байх.

**Бүрдүүлэх материал:**

- Төрийн албан хаагчийн анкет;
- Иргэний үнэмлэхийн хуулбар;
- Болговсролын түвшинг тодорхойлсон баримт бичиг /диплом/, хэрэв гадаад улсад их, дээд сургууль төгссөн бол боловсролын баримт бичгийн баталгаат орчуулгыг хавсаргах;
- Мэргэшүүлэх сургалтад хамрагдсаныг гэрчлэх баримт бичиг;
- Нийгмийн даатгалын дэвтэр /Хөдөлмөрийн дэвтэр/-ийн хуулбар, цахим лавлагаа;
- Албан тушаалд томилогдсон, чөлөөлөгдсөн тушаал, шийдвэрийн хуулбар;
- Төрийн жинхэнэ албаны тангараг өргөсөн “Тангаргийн хуудас” хуулбар;
- Сүүлийн гурван жилийн төрийн албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлсэн илтгэх хуудас, төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээ;
- Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх тухай тодорхойлолт /e-mongolia-аас татан авах/.

**Материал хүлээн авах:**

- Хугацаа: 2024 оны ... сарын ...-ний өдрийн 18.00 цаг хүртэл
- Хүлээн авах хаяг, холбоо барих утасны дугаарыг жагсаалтаас харна уу.

## ШИЛЖҮҮЛЭХ, СЭЛГЭН АВАХ АЖЛЫН БАЙРНЫ ЖАГСГАЛТ

Ерөө сум

2024.10.25

№	Байгууллага	Дотоод нэгж	Албан тушаал	Орон тоо	Албан тушаалын		Боловсрол	Мэргэжил	Мэргэшил	Туршлага
					Төрөл	Ангилал, зэрэглэл				
<b>СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЕРӨӨ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР</b> Хүлээн авах хаяг: <a href="mailto:Eruee@selenge.gov.mn">Eruee@selenge.gov.mn</a> цахим шуудангаар Холбоо барих утас: 99245745, 94546000										
1	Ерөө ЗДТГ		Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн	1	Гүйцэтгэх	ТЗ-9	Дээд	Хүрээлэн буй орчин судлал /052/, Хүрээлэн буй орчныг хамгаалах технологи /0712/, Уул уурхай олборлолт /0724//, аялал жуулчлал /101501/	Байгаль орчны салбарын мэргэшүүлэх сургалтад хамрагдсан бол давуу тал болно.	Мэргэжлээрээ ажилласан бол давуу тал болно
2	Ерөө ЗДТГ		Нийгмийн бодлогын мэргэжилтэн	1	Гүйцэтгэх	ТЗ-9	Дээд	Боловсрол /011/, эрүүл мэнд, нийгэм хамгаалал /09/, хүмүүнлэг /022//, Социологи-соёл судлал /0314/, төрийн удирдлага /041303/ гэр бүл судлал	Нийгмийн ухааны салбарын мэргэшүүлэх сургалтад хамрагдсан бол давуу тал болно.	Мэргэжлээрээ ажилласан бол давуу тал болно

Захиалга өгсөн: Ерөө сумын Засаг даргын Тамгын газрын дарга

С.Цэвэлмаа

